



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/529

Булган сум

Г Гэрээ байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны III/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын буриадын “Ёохор хатираа” оройн арга хэмжээнд хэрэглэгдэх дэлгэц, гэрэл түрээслэх, салют худалдан авахад 17,500,000 (арван долоон сая таван зуун мянга) төгрөг, “Бадмаа, Чагдар хоёр” контент бүтээхэд шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Ажил гүйцэтгэх байгууллагуудтай гэрээ байгуулах эрхийг Соёл, урлагийн газрын дарга (Г.Алдармөнх)-д олгож, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

3. Дээрх хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010705

07 дугаар сарын 23-ны өдрийн 1529 дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн хавсралт



“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын дэлгэц, гэрэл,
салютын зардлын тооцоо

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
1.	Салют /4минут/	1 минут/3,500,000/	3,500,000	14,000,000
2.	Дэлгэц /түрээс	3x5м	2,000,000	2,000,000
3.	Пар гэрэл, Мак гэрэл түрээс	30 ширхэг	1,500,000	1,500,000
4.	Бадмаа чагдар контент бүтээх	5,000,000	5,000,000	5,000,000
Нийт дүн				22,500,000